

**ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2016.01.22

Төв аймаг

Зорилго: Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд ил тод тунгалаг, нээлттэй, шударга, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмж, үр ашгийг сайжруулан, иргэдийн сэтгэл ханамжийг дээдэлж, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд оршино.

Дэвшүүлсэн зорилт:

1. Төрийн үйл ажиллагааны ил тод, тунгалаг байдлыг хангана.
2. Удирдлага, хяналтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, шударга байдлын үнэлгээг ахиулна.
3. Байгууллагын удирдлагуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлтыг сайжруулна.
4. Төсөв, санхүү, аудитын ил тод байдлыг хангана.
5. Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
6. Иргэний нийгмийн байгууллага, ТББ-ын идэвх санаачилга, оролцоог дэмжих, хамтран ажиллана.
7. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сайжруулна.

Зарчим: Хууль дээдлэх, хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, нийтийн ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг баримтална.

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Төсөв санхүү	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах эзэн/ тайлбар
1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ							
1	Төрийн бүх шатны байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх	1.1 Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батлуулах, үнэлгээ дүгнэлт гаргуулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тусгана.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байна. ИТХ-ын Тэргүүлэгчдэд хагас, бүтэн жилээр тайлагнана.	Нийт 5254.0 сая төгрөг	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг сум, байгууллага бүр дагаж мөрдөнө.	2016 онд	Аймгийн ЗДТГ, Хууль зүйн хэлтсийн дарга М. Мэндсүрэн Хуулийн мэргэжилтэн Л. Цэрэнноров ТЗУХ-ийн мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн Н.Эрдэнэболд,

							3.Хүүлээхан 27 сум, 26 хэлтэс агентлагуудын ОНИМТ-ийн мэргэжилтэн хамрагдана.
2	Төрийн байгууллагын ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдлагын эрх үүргийг хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх тайлбарлах	2.1Төрийн бүх шатны байгууллагуудын удирдлагууд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж олон нийтэд нээлттэй мэдэгдэл хийх, ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдэгдлийг гаргаж хэвшүүлнэ.	Төрийн албыг төлөвшүүлэн хөгжүүлэх, албан хаагчдын манлайлах хүчин чармайлтыг ахиулна.	160.0 төгрөг	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сайжирна.	2016 оны 01-р сард	Хууль зүйн хэлтэс Л. Цэрэнноров Сумдын ЗДТГ-ын ЭБАТ нар
3	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх Эрх зүйн үндэслэл: • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6	3.1Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг батлах, албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хамт олонд мэдээлнэ. Цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулна. 3.2 Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах утас, хайрцаг ажиллуулж тухай бүр нь мэдээлнэ. 3.3Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө мэдээллээр төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтанд хүргэнэ. 3.4.Зөрчил илэрсэн тохиолдолд цаг хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх, шударга байдлыг тогтоох, байгууллагын хурлаар авч хэлэлцэн гарсан шийдвэрийг дагаж мөрдөнө.	Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх Хуульд зааснаар	Төсөв шаардагдахгүй	Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага сайжирна.	2016 оны 02-р сард	Аймгийн ЗДТГ-ын дарга Д.Нямдорж ТЗУХ-ийн дарга Б. Цогбаяр Хууль зүйн хэлтсийн дарга М. Мэндсүрэн Хуулийн мэргэжилтэн Л. Цэрэнноров
4	Авлигын эсрэг соён	4.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс	Авлигаас	148.0 төгрөг	Төрийн	2016 оны 2-	Аймгийн ЗДТГ-ын

	гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх Эрх зүйн үндэслэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2;	урьдчилан сэргийлэх нэгдсэн болон хэсэгчилсэн сургалтыг төрийн бүх шатны байгууллагыг хамруулан зохион байгуулна.	урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ахиц гаргана.		байгууллагуудын уялдаа, холбоо сайжирсан байна.	р сард	Хууль зүйн хэлтэс, төрийн бүх шатны байгууллага
		4.2 Төрийн байгууллага бүр жилд 2-оос доошгүй удаа дотооддоо / суманд/ сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөг зэрэг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлднэ.	Иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ.	Тухай байгууллага хариуцна.	Авлигын эсрэг үйл ажиллагааны үр нөлөө сайжирч	Тухай бүр	Төрийн бүх шатны байгууллагууд
		4.3 Авлигаас ангид –Төв аймаг аяныг 3 сарын хугацаатай төрийн бүх шатны байгууллагуудын дунд зохион байгуулна. / “Хуулиа дээдлэе, ёс зүй, хариуцлага”-тай байцгаая сэдэвт дэвжээ тэмцээн, “Шинэ санаачилга, шинэлэг үйлчилгээг иргэдэд” гэсэн сэдэвт арга хэмжээг зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах дэвтэр, хайрцаг аялуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.	Соён гэгээрүүлэх ажлыг өмнөх оныхоос 1 дахин нэмэгдүүлнэ.	2446.0 төгрөг	Иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ.	2016 оны 03-06-р сарын хооронд	Төрийн бүх шатны байгууллагууд хамрагдана. Ерөнхий зохион байгуулагч аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс
5	Аймгийн хэмжээний Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын судалгааг гаргах	5.1 Төрийн бүх шатны байгууллагуудын шударга байдлын үнэлгээ, иргэдийн төсөөллийн судалгааг /2016-2020 онд ямар түвшинд байхыг тогтоох/ 27 сум, 26 хэлтэс агентлагыг хамруулан, ТББ-тай хамтран зохион байгуулна.	2016-2020 оны авлигын индексийн судалгааг байгууллага тус бүрээр гаргаж, судалгааны үндсэн дээр нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	1сая төгрөг	Байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө сайжирсан.	Жилдээ	Ерөнхий зохион байгуулагч аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс Төрийн бүх шатны байгууллагууд хамрагдана. ТББ-уудтай хамтарна.
6	Сум, Байгууллагуудын хяналт шалгалтыг зохион байгуулна.	6.1 Сум, байгууллагын шударга ёс, хариуцлага, нээлттэй ил тод байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шалган тусалж, арга зүйн зөвлөгөө болон сум, байгууллагын үйл	Сумдыг 4 бүс, байгууллагыг үйл ажиллагааны чиглэлээр хуваан ЗГ-ын 143-р, авлигын эсрэг	Шатахууны зардал 1120.0 сая төгрөг	Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй, хариуцлагатай	2016 оны 10-р сард	Аймгийн ЗДТГ, ТЗУХ, Хууль зүйн хэлтэс, ТББ-уудтай хамтарна.

		ажиллагааны түвшинг тогтооно.	хууль, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийг баримтална.		байдлын түвшин дээшилнэ.		
--	--	-------------------------------	---	--	--------------------------	--	--

1. ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2.</p>	<p>1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилна. /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/</p> <p>1.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээнэ.</p>	<p>“Одонт хөтөлд” авлигаас ангид сурталчилгааны самбар байрлуулна.</p> <p>Сурталчилгааны материалыг түгээсэн баримтыг цахим хуудсанд байршуулна.</p>	<p>380.0 төгрөг</p> <p>Төсөв шаардагдахгүй</p>	<p>Олон нийтэд сурталчилан таниулсан байна.</p>	<p>2016 оны 4-р сард</p> <p>2016 оны 2-р сард</p>	<p>Аймгийн ЗДТГ, Хууль зүйн хэлтэс</p> <p>Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн Л.Цэрэнноров</p>
2	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах,</p>	<p>2.1. Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, бусад нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>Олон нийтийн хяналтыг бэхжүүлж, иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг, оролцоог</p>	<p>Төсөв шаардагдахгүй</p>	<p>Мэдээллийн ил тод байдал, хүртээмж сайжирсан байна.</p>	<p>Тухай бүр</p>	<p>Хууль зүйн хэлтэс Б. Оюунцэцэг Сумдын ЗДТГ-ын ТЗХЭЗ-н мэргэжилтэн</p>

	сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5	2.2.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, бусад нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулна. 2.3.Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдийн санал хүсэлтийг сонсох ажиллагаа хийж, хариуг хуулийн хугацаанд мэдэгдэнэ.	хангагдана.				
3	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	3.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилгыг өрнүүлэх /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/ уг арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна. 3.2.Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санал санаачилгыг олон нийтэд сурталчилна. / уриа, уриалга, мэдэгдэл гэх мэт/ 3.3. Байгууллага бүр удирдлагынхаа хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаасаа санал асуулга, асуумж, судалгааны аргаар үнэлгээ тогтоолгож дүнг аймагт нэгтгэн тооцно.	Аймгийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлыг байгууллагуудын удирдлагуудын санал, санаачилга, хүсэл, эрмэлзлийг харгалзан үзнэ.	Төсөв шаардлагагүй	Төрийн бүх шатны байгууллагуудын удирдлагуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл нэмэгдэнэ.	Тухай бүр Тухай бүр Хагас бүтэн бүр	Аймаг, сумдын ЗДТГ, хэлтэс, агентлагууд хамаарна.
1.1 ХЯНАЛТ ШАЛГАЛТ							
4	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах Эрх зүйн үндэслэл:	4.1.Тухайн жилд явуулах дотоодын хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулна. 4.2. Дотооддоо хийсэн хяналт шалгалтын дүн, шалгалтын мөрөөр авч	Хяналт шалгалтаар явсан ажлын тайлан, дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох	Төсөв шаардагдахгүй	Мэдээллийн ил тод байдал сайжирсан байна.	Улирал бүр	Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, Санхүүгийн хяналт Дотоод аудитын алба хяналт шинжилгээ

	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 	хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар олон нийтэд цахим хуудас болон мэдээллийн самбар, /нийтийг хамарсан арга хэмжээний үед/ төрөл бүрийн хэлбэрээр илэрхийлж, танилцуулна.	арга хэмжээг авсан эсэх үр дүнгийн талаар мэдээлнэ.				үнэлгээний алба, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн байгууллага,
--	--	---	---	--	--	--	---

1.2 ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

5	<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 	<p>5.1. Тухайн жилийн батлагдсан төсвийг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд танилцуулна.</p> <p><i>/1 дүгээр сарын 10-ны дотор/</i></p>	<p>Төсөв санхүүгийн мэдээлэл үнэн зөв, бодит байх зарчимд нийцүүлэн тогтмол шуурхай мэдээлэх үйл ажиллагааг жигдрүүлэх</p>	Төсөв шаардлагагүй	Төсөв санхүүгийн ил тод байдал сайжирна.	Хуулийн хугацаанд	<p>Аймаг, сумдын ЗДТГ, төсөвт байгууллагууд, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба Сумдын ЗДТГ-ын дарга нар сум, байгууллагуудын нягтлан бодогч, сумдын Төрийн сангийн мэргэжилтнүүд</p>
		<p>5.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/ цахим болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулж мэдээлсэн байна.</p>		Төсөв шаардлагагүй	Шилэн дансны тухай хууль, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт ахиц гарна.	Хуулийн хугацаанд	
		<p>5.3. Сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүрт байршуулж иргэдэд мэдээлнэ.</p> <p><i>/дараа сарын 8-ны дотор/</i></p>	<p>Мэдээллийг тогтмол шинэчилж, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой болгох</p>	Төсөв шаардлагагүй	Иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмж сайжирна.	Сар бүр	
		<p>5.4. Улирлын төсвийн гүйцэтгэл цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүрт байршуулж иргэдэд мэдээлнэ.</p> <p><i>/дараа сарын 8-ны дотор/</i></p>				Улирал бүр	
<p>5.5. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүрт байршуулж иргэдэд мэдээлнэ.</p> <p><i>/8 дугаар сарын 15-ны дотор/</i></p>	Хагас бүтэн жилээр						

		5.6. Хагас жилийн санхүүгийн тайланг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулж иргэдэд хүргэх мэдээллийг хүртээмжтэй болгоно. <i>/8 дугаар сарын 15-ны дотор/</i>					
		5.7. Дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд иргэдийн өгсөн саналыг харгалзан төсөлд тусгуулна. <i>/9 дүгээр сарын 15-ны дотор/</i>	Тухайн байгууллага, албан тушаалтан төсөв санхүүгийн төлөвлөлтийг иргэдийн санал хүсэлтийг харгалзан үзнэ.	Төсөв шаардагдахгүй	Иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмж, цар хүрээ нэмэгдэнэ.	2016 оны 9,10-р сард	Санхүү төрийн сангийн ахлах мэргэжилтэн Ч. Цэцэгсүрэн Сумдын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн төрийн байгууллагуудын төсөв санхүү хариуцсан мэргэжилтэнгүүд
		5.8. Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд танилцуулна. <i>/4 дүгээр сарын 25-ны дотор/</i>	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулж, шаардлагатай бол хуульд заасан журмыг баримтална.	Төсөв шаардагдахгүй	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	Хуулийн хугацаанд	Санхүү төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч Э. Нарантуяа Сумдын төрийн сангийн мэргэжилтэнгүүд
		5.9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан олон нийтэд мэдээлнэ. <i>/4 дүгээр сарын 25-ны дотор/</i>	Хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.	Төсөв шаардагдахгүй	Шилэн дансны тухай хууль болон мэдээллийн ил тод байдал сайжирна.	Хуульд заасан хугацаанд	Үндэсний аудит газар
		5.10. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийг цахим хуудас болон	Бүх шатны ИТХ болон Аудитын байгууллага хяналт тавина			Хуульд заасан хугацаанд	

	<p>мэдээллийн хэрэгслээр олон нийт болон, байгууллагуудад танилцуулна. <i>/7 дугаар сарын 1-ний дотор/</i></p>					
	<p>5.11. Төсвийн хэмнэлт, хэлтрэлт, түүний шалтгааны тайлбарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулж, олон нийтэд танилцуулна. <i>/улирал бүр/</i></p>	<p>Дээрх мэдээллүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан нийтийг хамарсан арга хэмжээний үеэр танилцуулж, тайлбар мэдээлэл өгнө.</p>		<p>Мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт дээшилнэ.</p>	<p>Улирал бүр</p>	<p>Санхүү төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч Э. Нарантуяа Сумдын төрийн сангийн мэргэжилтэнгүүд Төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч нар</p>
	<p>5.12. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн мэдээг цахимдаа тцха бүр байршуулна. <i>/өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор/</i></p>					
	<p>5.13. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгож /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ цахим хуудсандаа байршуулан боломжит бүх хэлбэрээр иргэдэд мэдээллийг хүргэнэ.</p>	<p>Төсвийн орлого бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хуулийн дагуу үнэн зөв, ойлгомжтой, нээлттэй байдлаар иргэдэд хүргэсэн байх</p>	<p>Төсөв шаардлагагүй</p>	<p>Төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт дээшилнэ.</p>	<p>Сар бүр</p>	<p>Татварын хэлтэс, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, сумдын Татварын байцаагчид</p>
	<p>5.14. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг тухай бүр цахим хуудас болон мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр танилцуулна. <i>/өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/</i></p>	<p>Хууль тогтоомжид зааснаар</p>	<p>Төсөв шаардлагагүй</p>	<p>Төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт дээшилнэ.</p>	<p>Хуульд заасан хугацаанд</p>	
	<p>5.15. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулна. <i>/гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор/</i></p>	<p>Хуульд тогтоомжид зааснаар</p>	<p>Төсөв шаардлагагүй</p>	<p>Төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт дээшилнэ.</p>	<p>Хуульд заасан хугацаанд</p>	<p>Санхүү төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч Э. Нарантуяа Сумдын төрийн сангийн мэргэжилтэнгүүд</p>

						Төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч нар
	5.16. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг цахим хуудсаар болон байгууллагын удирдлагуудын шийдвэрийг олон нийтэд ил тод мэдээлнэ. / <i>өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор</i> /	Хууль тогтоомж болн журамд заасны дагуу хэрэгжүүлнэ	Төсөв шаардлагагүй	Мэдээллийн ил тод байдал сайжирсан байна.	Хуульд заасан хугацаанд	Аймгийн ЗДТГ-ын удирдлагууд, албан байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч
	5.17. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг олон нийтэд шуурхай мэдээлнэ. / цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр г.м/ <i>/батлагдсанаас хойш 7 хоногийн дотор/</i>	Хууль тогтоомж, журамд нийцүүлнэ.	Төсөв шаардлагагүй	Төсөт санхүүтэй холбоотой мэдээ, мэдээллийн ил тод нээлттэй, тунгалаг байдал дээшилнэ.	Хуульд заасан хугацаанд	Аймгийн ЗДТГ Санхүү төрийн сангийн хэлтэс Хөгжлийн бодлогын хэлтэс,
	5.18.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тодорхой болгож нийтэд мэдээлнэ. /цахим хуудас самбараар, Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтийг хамарсан арга хэмжээ г.м/ бүх хэлбэрээр /	хууль тогтоомж, журамд заасан үзүүлэлтээр	Төсөв шаардлагагүй	Мэдээллийн ил тод байдал сайжирна	2016 оны 06, 12-р сард	Нийгмийн даатгалын хэлтэс
	5.19.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт					
	5.20.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл	Шилэн дансны хуульд заасан журмаар	Төсөв шаардлагагүй	Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	Хагас, бүтэн жилээр	Хөгжлийн бодлогын хэлтэс
	5.21. Аймаг сум байгууллагын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар /	Хууль тогтоомжид зааснаар	Төсөв шаардлагагүй	Төрийн байгууллагууд	Улирал бүр	Санхүү төрийн сангийн хэлтэс Сум, байгууллагын дарга, эрхлэгч,
	5.22. аймаг, сум, байгууллагын төсвийн		Төсөв	ын мэдээллийн	Сар бүрийн	

		гүйцэтгэлийн сарын мэдээг цахим хуудсандаа тогтмол байршуулж хэвшинэ.		шаардлагагүй	ил тод байдалд ахиц гарна.	15-ны дотор	нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтэн
		5.23. Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг цахим болон мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд мэдээлнэ.	Хууль тогтоомжид зааснаар	Төсөв шаардлагагүй		дараа жилийн 8 дугаар сарын 25-ны дотор/	Санхүүгийн хяналт аудитын алба
		5.24. Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг цахим хуудас болон мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ашиглан танилцуулна. /бат-лагдсанаас хойш 7 хоногийн дотор/	Хууль тогтоомж, журам, гэрээг зэрэг баримт бичигт нийцүүлнэ.	Төсөв шаардлагагүй	Мэдээллийн ил тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	Хуулийн хугацаанд	Хөгжлийн бодлогын хэлтэс
		5.25. Концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа обайршуулна. /гэрээ байгуу-лагдсанаас хойш 7 хоногийн дотор/				Тухай бүр	Хөгжлийн бодлогын хэлтэс
		5.26. Концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр танилцуулна. /7 хоногийн дотор/				Тухай бүр	Хөгжлийн бодлогын хэлтэс

1.3 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

6	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг	6.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулна. 6.2.Дээрх зөвшөөрлийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулна. 6.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл,	Тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хамаарна.	Төсөв шаардлагагүй	Мэдээллийн ил тод байдал сайжирна.	Тухай бүр	Хөгжлийн бодлогын хэлтэс Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар Мэргэжлийн хяналтын газар Сумдын засаг дарга
---	--	--	--	--------------------	------------------------------------	-----------	---

	хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; <ul style="list-style-type: none"> Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 	зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулна. 6.4.Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгоно.	Байгууллагын нууц хөндөгдөхөөс бусад мэдээллийг нээлттэй иргэдэд хүргэнэ.	Төсөв шаардлагагүй	Иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмж сайжирна.	Сар бүр	Төрийн бүх шатны байгууллагад хамаарна.
7	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох Эрх зүйн үндэслэл: <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 	7.1.Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байна. 7.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгоно.	Төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тэнцвэртэй болгох	Төсөв шаардлагагүй	Ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үүргийн хуваарийг тэгш шударгаар хэрэгжүүлнэ	Хагас, бүтэн жилээр	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хууль зүйн хэлтэстэй хамтрах
8	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах Эрх зүйн үндэслэл: <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3 	8.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байна. /1 ба түүнээс дээш/ 8.2. Үйл ажиллагаа явуулж байгаа 4 төрийн бус байгууллагатай хамтран /Эмэгтэйчүүдийн зөвлөл, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Ахмад багш нарын чөлөөт холбоо, Залуу манлайлагч клубтэй хамтран өдөрлөг, уулзалтыг иргэдийн дунд зохион байгуулна. 8.3.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа тухай бүр мэдээлнэ.	Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын уялдаа холбоог сайжруулж, шинэ шатанд хүргэнэ.	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд тусгагдсан төлөвлөгөөнд багтсан болно.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжиж, төрийн үйл ажиллагаанд ахиц гаргана.	2016 оны хагас, бүтэн жилээр	Аймгийн ЗДТГ төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.
9	Авлигын эсрэг хууль тогтоомжийн	9.1.Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал,	Авлигын эсрэг үйл ажиллагаа болон	Төсөв шаардлагагүй	Авлигын эсрэг хууль	Жилдээ	Хууль зүйн хэлтэс Л. Цэрэнноров

	<p>хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 	<p>хариуцлагыг тогтоож тусгай журам боловсруулж, дагаж мөрдүүлнэ.</p> <p>9.2.ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байна.</p> <p>9.3.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад ЭБАТ-уудыг хамруулна</p>	<p>ХАСХОМ-ын тайланг эрх бүхий албан тушаалтанд тайлагнаж, мэдээллээр хангана.</p>		<p>тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөө ахиц гарна.</p>		<p>Салбар ЭБАТ-ууд хамааралтай</p>
		<p>9.4.Сум байгууллагуудын ЭБАТ-ын үйл ажиллагааг тусгай үзүүлэлтээр дүгнэж, байгууллага, сумдын удирдлагад танилцуулж, цахим хуудсанд байршуулна.</p>	<p>ЭБАТ-ны ажиллах үйл ажиллагааны болон урамшуулал олгох журмыг ИТХ-аар батлуулан нэг мөр болгоно.</p>	<p>Төсөв шаардлагагүй</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомж, Хувь хүний нууцын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.</p>	<p>Жилдээ</p>	<p>Хууль зүйн хэлтсийн дарга М. Мэндсүрэн Хуулийн мэргэжилтэн Л. Цэрэнноров Салбар ЭБАТ-ууд хамааралтай</p>
<p>10</p>	<p>Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 	<p>10.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байна.</p> <p>10.2.Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд удирдах албан тушаалтнаас зөвшөөрөл олгодог байх, энэ талаар бүртгэл судалгаатай болно.</p>	<p>Давхар ажил эрхлэлтийн судалгаа, мэдээллийг авч олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг гүйцэтгэх</p>	<p>Төсөв шаардлагагүй</p>	<p>Давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох үйл ажиллагаа хуулийн дагуу олгогдож байх</p>	<p>2016 оны 2-р сард</p>	<p>Хууль зүйн хэлтэс Хэлтэс, агентлаг, сумдыг хариуцсан салбар ЭБАТ-ууд</p>

	дүгээр зүйл						
11	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5 	<p>11.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байна./цахим хуудсандаа тусгай цэстэй болох/</p> <p>11.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг /тушаал, захирамж, тогтоол/-ийг батлагдсан даруйд нь цахим хуудсандаа байршуулна.</p> <p>11.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулна.</p> <p>11.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулна.</p>	<p>Байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх хяналт тавих, төлбөр хураамжийн мэдээг шинэчлэн гаргаж иргэдэд хүргэсэн байдал</p>	Төсөв шаардлагагүй	Мэдээллийн ил тод байдал сайжирна.	Тухай бүр	Төрийн бүх шатны байгууллагад хамаарагдана.
12	<p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2; • Нийтийн албанд нийтийн болон 	<p>12.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байна.</p> <p>12.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)</p> <p>12.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах</p> <p>12.4.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байна.</p>	<p>Засгийн газрын 7027-1111,авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх 1800-1969 утсанд ирүүлсэн мэдээллийг харгалзан үзнэ.</p>	Төсөв шаардлагагүй	Иргэдийн сэтгэл ханамж дээшилж, мэдээллийн ил тод байдал сайжирсан байна.	Тухай бүр	ТЗУХ, Хууль зүйн хэлтэс, төрийн бүх шатны байгууллагууд хамаарна.

	<p>хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;</p> <p>Иргэдээс төрийн байгуул-лага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомд-лын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг</p>						
13	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 	<p>13.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байна.</p> <p>13.2.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/</p>	Авлигын эрсдэл буурсан байна.	Төсөв шаардлагагүй	Авлигад өртөх эрсдэлтэй ажил үйлчилгээний жагсаалтыг гаргаж, шинэчилсэн байна.	2016 оны 2-р сард	Хууль зүйн хэлтэс ЭБАТ Л. Цэрэнноров Бусад хэлтэс, агентлаг, сумдын ЭБАТ –д хамааралтай.
14	<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p>	<p>14.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээг тухай бүр цахим хуудсандаа байршуулна.</p> <p>1342.АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг</p>	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангуулна.	Төсөв шаардлагатай Тодорхой бус Тухай бүр	Шударга байдлыг үнэлгээнд ахиц гарна.	Тухай бүр	Аймгийн ЗДТГ-ын дарга Д. Нямдорж, Хууль зүйн хэлтсийн дарга М.

	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 	<p>арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдалд тулгуурлан хэрэгжүүлнэ.</p> <p>14.3.АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээг хуулийн дагуу гүйцэтгэнэ.</p> <p>14.4.АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хуульд зааснаар шийдвэрлэнэ.</p> <p>14.5.Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосныг тухай бүр цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж мэдээлнэ.</p> <p>14.6.АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахил-гын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлсэн байдлыг олон нийтэд мэдээлнэ.</p>					Мэндсүрэн ХЗХ-ийн ЭБАТ Л. Цэрэнноров
15	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	<p>15.2.Албан хаагчдын үр дүнгийн гэрээг үнэлж дүгнэсэн дүн, үйл ажиллагаандаа зөрчил, дутагдал гаргасан бол уг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг мэдээллийн самбарт болон цахим хуудсанд байршуулна. / тухайн албан хаагчийн эрх ашиг сонирхлыг зөрчихгүй байх зарчмыг баримтална./</p> <p>15.3.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил илэрсэн тохиолдолд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар цахим хуудсанд байршуулж мэдээлнэ. / хууль</p>	Албан хаагчдын ажлын хариуцлагад ахиу гаргана.	Төсөв шаардлагагүй	Хариуцлагын тогтолцоог шударга болсон байна.	Улирал тутам	Санхүүгийн хяналт , дотоод аудитын алба Хууль зүйн хэлтэс Төрийн захиргаа удирдлагын хэлтэс

		журмын дагуу эрх ашиг сонирхлыг хөндөхгүй байх зарчим баримтална./					
		15.4.Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, дутагдлыг шалган үзэж, нотлох баримтаар нотлогдсон тохиолдолд авсан арга хэмжээг цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.					
		15.5.Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг /шүүхээр шийдвэрлэгдсэн/ ба бусад зөрчлийг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд мэдээлнэ.					

1.4 ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

16	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Хуулийн 8 дугаар зүйл Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай 	<p>16.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулна. /тухай бүр шинэчилсэн/</p> <p>16.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.</p> <p>16.3 Байгууллагын дотоод журам, албан хаагчдын ёс зүйн дүрэм, хүний нөөцийн стратеги түүний хэрэгжилт, хянаж үнэлсэн журмыг цахимд байршуулах, тухай бүр мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулна.</p> <p>16.4 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд удирдлагын ил тод байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэн, мэдээллийн самбарт болон ДУС—ын олон нийтийн буланд байршуулна. / үр дүнгийн гэрээ, Нийгмийн хариуцлагын гэрээ, гурвалсан гэрээ г.м/</p> <p>16.5Хүний нөөцийн удирдлагын ил тод бйдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээий талаар цахим, болон олон нийтэд мэдээлнэ.</p>	Хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөгө болгон ажиллах	Төсвийг тухайн үеийн нөхцөл байдалд тулгуурлана.	Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй ил тод нээлттэй байдлыг 100% хангасан байна.	Тухай бүр	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс Хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ
----	--	--	---	--	--	-----------	---

1.5 ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

17	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;	17.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулна.	/1 дүгээр сарын 10-ны дотор/	Төсөв шаардлагагүй	Иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмж сайжирсан байна.	Тухай бүр	Худалдан авах ажиллагааны алба Тендерийн хороо Иргэний нийгмийн байгууллага
		17.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байна.	Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлтийг харгалзах				
		17.3.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй, шалтгааныг цахим хуудсанд байршуулна.	Хуулийн үндэслэлтэйгээр				
	Төрийн болон орон нут-гийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5	17.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулна.	Хууль дүрэм, журмын дагуу зохион байгуулна.	Төсөв шаардлагагүй	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хариуцлага дээшилнэ.	Сар бүр	Аймгийн ЗДТГ, ХЗХ, Худалдан авах ажиллагаа, Иргэний зөвлөл хамаарна.
		17.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт,шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулна					
		17.6.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна					

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ХЗХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л. ЦЭРЭННОРОВ

ХЯНАСАН:
ДАРГА

М. МЭНДСҮРЭН